



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 08 өдөр

Дугаар A/66

Улаанбаатар хот

Г Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалт, Газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн 2023 оны 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг зөвлөмж, арга зүйгээр хангах, сурталчлах зорилгоор хотын стандартыг нэмэлтээр хэвлүүлэх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хэвлэлтийн тоо хэмжээ, нийт зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хотын стандартыг хэвлүүлэхэд шаардагдах 33,030,000 (Гучин гурван сая гучин мянга) төгрөгийг Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3. Хэвлэлтийн ажилд хяналт тавьж, хавсралтад дурдсан тоо хэмжээний дагуу актаар хүлээж авахыг Ажлын хэсэг (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

